

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НУТАГ
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ ҮЙЛДВЭР”-ИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/5554861/

УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА	ХУУДАСНЫ ДУГААР
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	3
1.2 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	3
1.3 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	3
1.4 Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	3
1.5 Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	3
1.6 Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
2.1 Нийгмийн үзүүлэлт	4
2.2 Эдийн засгийн үзүүлэлт	5
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
3.1 Төслийн товч тодорхойлолт	6
3.2 Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл	6
3.2.1 Шууд нөлөөлөл	7
3.2.2 Шууд бус нөлөөлөл	7
3.3 Нөлөөллийн үргэлжлэх хугацаа	7
3.4 Нөлөөллийн эрчим	7
3.5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	7
3.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	7
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	8
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8
4.2 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	8
4.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	9
4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	9
4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	9
4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	9
4.6.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ	10
4.6.2 Хөрсөн орчны хяналт шинжилгээ	10
4.6.3 Усан орчны хяналт шинжилгээ	10

4.7 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	11
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
5.1 Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.2 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	14
5.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
5.4 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	18
5.5 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
5.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	23
5.7 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	25

**НЭГ.УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ “ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЮУЛТАЙ, ЭРСДЭЛТЭЙ ХОГ
ХАЯГДЛЫГ УСТГАХ ҮЙЛДВЭР”-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Элемент Медикал” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011327098
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах, бутлах, шатаах, ландфиллдэх
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	СХД 36-р хороо Толгойт /18105/6-р хэсэг 69 тоот
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ерөнхий захирал Б.Пүрэвсүрэн Утас:99099944 Цахим хаяг: elementmedical44@gmail.com
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ерөнхий менежер О.Дорж Утас: 88057656 Цахим хаяг: elementmedical44@gmail.com Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан М.Айдынгүл Утас: 99225658 Цахим хаяг: aidyngulmingai@gmail.com
1.2	1. Төслийн нэр	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал устгах үйлдвэр
	2. Төслийн харьяаллын байршил	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 36-р хороо
	3. Төслийн ангилал	Жижиг дунд үйлдвэр
	4. Төсөл эхэлсэн огноо	2009.10.25
	5. Төсөл хэрэгжих хугацаа	Хугацаагүй
	6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	2013 оны 7-р сарын 20-нд барилга байгууламжийг ашиглалтанд оруулах Улсын комиссын болон техникийн комиссын акт гарсан.
	7. ТЭЗҮ баталсан огноо	2008
	8. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	1380.2 тн ЭМБ-ын аюултай хог хаягдал хүлээн авч аюулгүй болгон устгасан.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Нийгэм, эдийн засгийн нөхцөл

2.1 Нийгмийн үзүүлэлт

УИХ-ын 18 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 100 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй анхны хуралдааныг 1992 оны 9 дүгээр сарын 19-ны өдөр хийжээ. Анхны хурлаас нийслэлийн Сонгинохайрхан дүүргийг 1992 оны 10 дугаар сарын 1-ний өдөр байгуулах тогтоол гарсан. Тус дүүрэг нь байгуулагдахдаа Сонгино нэртэй байв. 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 39 тоот “Дүүргийн нэрийг өөрчлөх тухай” тогтоолоор Сонгинохайрхан дүүрэг болгон өөрчилжээ. Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу зохион байгуулалтын өөрчлөлтөөр ийнхүү Нийслэлийн Октябрь район буюу одоогийн Баянгол дүүргээс өрх тусгаарлан байгуулагдсан. Нийслэлийн баруун жигүүрт Баянгол дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр сумдтай хил залган оршдог. Сонгинохайрхан дүүрэг нь өдгөө 120,1 га нутаг дэвсгэрт, 43 хороонд хуваагдан 95.8 мянга гаруй өрхийн 341.3 мянган хүн амтай, 27 мянга гаруй аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг томоохон дүүргийн нэг болсон. Мөн Монгол Улсын нийт хүн амын 11.6 хувь, Нийслэлийн нийт хүн амын 22.8 хувь, орон сууцны хорооллын 27.1 хувь, гэр хорооллын 72.9 хувь тус дүүрэгт байдаг. Засаг захиргааны анхан шатны нэгж 43 хороотой. Орон сууцны 12 хороо, гэр хорооллын 22 хороо, холимог 9 хороо оршдог. Дүүргийн хэмжээнд 83687 толгой малтай. Үүнээс тэмээ 23, үхэр 26764, адуу 13926, хонь 20917, ямаа 22057 толгой малтай байна.

Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээний дийлэнх хувийг хангадаг Улсын хэмжээний томоохон “Сүү” ХХК, “Талх чихэр” ХХК, “Алтан тариа” ХХК, “Мах импекс” ХХК, “Тесо” ХХК, “Милл хаус” ХХК, “Арвайн үндэс” ХХК зэрэг үйлдвэр, барилгын материалын “Хангай” зах, тоосгоны үйлдвэр болон хүнс худалдаа, үйлчилгээний 12500 гаруй аж ахуй нэгж, байгууллагууд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн төв, салбар 3 амбулатори, Нэгдсэн эмнэлэг, салбар 1 амбулатори, 26 өрхийн эрүүл мэндийн төвүүд болон нийт 31 нэгжид 706 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнууд дүүргийн 342 мянга гаруй иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүргэж байна. 2023 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн Ерөнхий боловсролын 35 сургуулийн 64851 суралцагч сурч байна. 2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 65, төрийн бус өмчийн 49, нийт 112 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Нийт сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 24202 хүүхэд хүмүүжиж байна.

Тус хороо нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 25/21 дүгээр тогтоолоор дүүргийн хэмжээнд хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж 26 дугаар хорооноос салбарлаж 2500 өрхийн 9437 иргэнтэйгээр 36 дугаар хороо байгуулагдан төрийн анхан шатны үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллаж байна. Алтан овоо 01-50 хүртэлх гудамжтай. Нутаг дэвсгэрт “Нарангийн энгэр”-ийн оршуулга, Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэг буюу Улаанчулуутын хогийн цэг байрладаг. Нийслэл хотын алслагдмал, хүн амын төвлөрөл нь хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд, түр оршин суугч ихтэй хороодын нэг юм. Хорооны нутаг дэвсгэрт 36 аж ахуйн нэгж байгууллагууд, СӨБ-ын 260, 263 дугаар цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. 2023 оны сүүлийн судалгаагаар хүн амын тоо 8240, өрхийн тоо 2383, ААН байгууллагын тоо 67, өрхийн эмнэлэг 1, ахуйн үйлчилгээ 2, дэлгүүр 28, ус түгээх байр 9 байсан байна. Үйлдвэрийн талбай нь засаг захиргааны хувьд Сонгинохайрхан дүүргийн дүүргийн 36-р хороонд харьяалагддаг. Мөн Эко паркийн хог хаягдал дахин

Элемент Медикал ХХК

боловсруулах төслийн талбайн хажууд 1,31 га талбайд үйлдвэрийн барилга байгууламж байрлан ажиллаж байна.

Хүснэгт 1. Сонгинохайрхан дүүргийн хүн амын тоо

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Хүн амын тоо, хүн	327580	335703	341540	342112	341390
Нийслэлийн хүн амын тоо	1466125	1499140	1539252	1596335	1640781
Нийслэлийн хүн амын тоотой харьцангуй хувь	22.3	22.4	22.2	21.4	20.8

2.2. Эдийн засгийн үзүүлэлт

Сонгинохайрхан дүүрэг нь Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж буй шилжилтийн эхэн үед байгуулагдсан бөгөөд энэ үед хүнсний томоохон үйлдвэрүүд ажиллаж байлаа. Улмаар үйлдвэрийн газрууд нэмэгдсэн бөгөөд 1993 онд аж үйлдвэрийн газрууд 412.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 2000 онд 15963.1 сая төгрөгийн, 2005 онд 34651.6 сая төгрөгийн 2013 онд 156161.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болсон байна.

Сүүлийн жилүүдэд бодит эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарыг жигд хөгжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлснээр ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулах боломж бүрдэж эхэлжээ. 2007 онд дүүргийн хэмжээнд 6380 ажлын байр шинээр бий болж, нутаг дэвсгэрийн аж ахуй нэгж байгууллагуудад зуучлах замаар 3163 хүнийг ажил хөдөлмөрт оруулж, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1594 болж, ажилгүйдлийн түвшин 1.2 хувь байсан байна. 2013 оны байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2619 болсон ба 14696 ажлын байр шинээр бий болсон байна. Ажилгүйдлийн түвшин 2.92 болсон байна.

Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 2000 онд 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо 106119 байсан ба үүний 42299 хүн буюу 39.8 хувь нь ажил эрхэлж байсан байна. 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 15 ба түүнээс дээш насны хүн амын тоо 191206 болж 2000 оныхоос 80 гаруй хувиар нэмэгдсэн бол ажил эрхэлж буй хүний тоо 2010 онд 83943 хүн болж 2000 оныхоос 98.4 хувиар өссөн байна. 2013 оны байдлаар 87092 ажиллагчид байгаагийн 40370 нь буюу 46.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 85862 -т хүрсэн бөгөөд үүний 32.2 хувь нь суралцагсад, 21.5 хувь нь тэтгэврийн насны хүмүүс, 15.4 хувь нь хүүхдээ асарч байгаа, 4.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 89710 байна. Хүн амын нийслэл хот руу шилжин суурьших хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой дүүргийн хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, 2000 онд 6154 хүн шилжин ирж, 5100 хүн шилжин явж байсан бол 2013 онд 30677 хүн шилжин ирж, 26065 хүн шилжин явсан байна. Мөн сүүлийн жилүүдийн нийгмийн халамжийн үйлчилгээ, хүн амын өсөлт зэрэгтэй холбоотой төрөлтийн тоо ихэссэн бөгөөд 1998 онд 2180 хүүхэд шинээр мэндэлж байсан бол 2000 онд 2689 хүүхэд, 2006 онд 4095 хүүхэд, 2009 онд 6329 хүүхэд, 2013 онд 8176 хүүхэд шинээр мэндэлсэн байна. Дүүргийн тоо малын тоо 2000 онд 48522 толгой мал байсан бол 2007 онд 75051 толгой мал болж 7.7 хувиар өсч байсан бол 2013 онд 56107 толгой мал болж 2007 оныхоос 25.2 хувиар буурсан байна. Учир нь нийслэл хотын оршин суугчдын эрүүл, аюулгүй байдлыг хангахын тулд нийслэл хотод мал, тэжээвэр амьтдын суурьшуулахгүй байх шийдвэрийн дагуу мал, тэжээвэр амьтад бүхий иргэд хотоос зайдуу суурьших болсонтой холбоотой малын тоо буурч байна. Иргэд малаас гарч байгаа ашиг шимийг нэмэгдүүлэхийн тулд эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх сонирхолтой болохын зэрэгцээ гахай, тахианы аж ахуйг ихээхэн хөгжүүлж байна. 1998 онд 310 гахай, 11285 шувуутай байсан бол 2007 онд 4483

Элемент Медикал ХХК

гахай, 23310 шувуу, 2013 онд 8681 гахай, 15434 шувуу болсон байна. Гахайн тоо 1998 оныхоос 28 дахин, шувууны тоо 36.7 хувиар өссөн бол 2007 оныхоос гахай 93.6 хувиар өсч шувууны тоо 33.7 хувиар буурсан байна. Сүүлийн жилүүдэд газар тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж нэмэгдэж үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалт нэмэгдэх хандлагатай болсон байна. Жишээлбэл: 2001 онд 294.5 га газарт тариалалт хийж байсан бол 2006 онд 420.6 га болж өссөн байна. 2013 онд 689.5 га болж, 2006 оныхоос 63.9 хувиар өссөн байна. Сүүлийн жилүүдэд иргэдийн амьжиргаа дээшилж байгаа бөгөөд дүүргийн авто машины тоо 2013 онд 45198 болсон байна. Энэ нь нийслэлийн нийт автомашины 17.6 хувь болж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Төслийн товч тодорхойлолт

Хог хаягдал устгах үйлдвэрийн төсөл нь Улаанбаатар хотын хог хаягдлын хэмжээг бууруулж, орчин үеийн техник технологийг ашиглан боловсруулалтанд оруулснаар байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн түүхий эдийг бэлтгэж хог хаягдлыг эдийн засгийн үр өгөөжтэйгээр ашиглах үндсэн зорилготой.

Тус үйлдвэр нь эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал, хуванцар хог хаягдал боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг Улаанбаатар хотод байрлаж буй ЭМБ-уудаас цуглуулж Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/505 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу тээвэрлэх, халдваргүйжүүлэх, утгах үйл ажиллагааг явуулж байна.

Эрүүл мэндийн байгууллагын аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг устгах үйлдвэрийн хүчин чадал нь 3500 тн/жил юм.

3.2 Төслийн гол болон болзошгүй нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлоход сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь хөрс, газрын гадарга, ургамал, амьтан байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн хэрэгжилтийн байдал болон орчны байдалтай танилцаж холбогдох судалгааг мөн хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал “х” –ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль

орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

3.2.1 Шууд нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн 13 (40.6%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, ургамлын бүтцийн өөрчлөлт, эвдрэл гарах, бэлчээр, агаар ба хөрсний бохирдол зэрэг нь шууд эерэгээр нөлөөлөх магадлалтай байна. Харин орон нутгийн нийгэм эдийн засагт шууд эерэгээр нөлөөлөхөөр байна.

3.2.2 Шууд бус нөлөөлөл

Нийт нөлөөллийн 4 (12.5%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Амьтдын орон зайн өөрчлөлт, гадаргын усны чанар, археологи, палеонтологийн олдворт шууд бус сөргөөр, үйлдвэр, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөхөөр байна.

3.3 Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөх эерэг ба сөрөг нөлөөллүүдийн дийлэнх нь урт хугацааны нөлөөлөлд хамрагдаж байна. Иймээс сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатай.

3.4 Нөлөөллийн эрчим

Төслийн сөрөг нөлөөлөл нь дундаас бага байгаа ба нийт 17 нөлөөллөөс 8 нь дунд зэрэг, 9 нь сул нөлөөлөл бөгөөд 11 нь сөрөг, 6 нь эерэг нөлөөлөл байна. Иймээс байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг төслийн үйл ажиллагаатай холбож боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.

3.5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

“Элемент Медикал” ХХК-ийн “Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдал цуглуулах, устгах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаварыг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн 7 чиглэлийн 50 бүлэг үйл ажиллагааны зөвлөмж боловсруулав. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хууль эрхзүйн бүлэгт орсон хууль, дүрэм журам, стандарт болон Олон улсын конвенцийн холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Ингэснээр төслөөс бий болох болох эрсдэл, сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ.

3.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ий тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, *Элемент Медикал ХХК*

аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав. Энэ жилийн орчны хяналт шинжилгээний ажлын зардал 4 900 000 төгрөг, БОМТ-ний урьдчилан тооцоолсон нийт зардал 150 700 000 төгрөг

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“ЭЛЕМЕНТ МЕДИКАЛ” ХХК нь хүний эрүүл мэнд болон Байгаль орчинд хор нөлөөгүй олонхын баримтлан ашиглаж байгаа зөвшөөрөгдсөн арга технологийг МУ-ын Хог хаягдлын хууль, Байгаль орчны холбогдох хуулиудад нийцүүлэн Монгол Улсын үндсэн хуулийн заалт болох Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцөлийг хангахад бидний гол зорилт оршино. Үүний дагуу 2025 онд дараах чиглэлээр төлөвлөж ажиллаж байна.

1. Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

4.1 Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлоход төслийн явцад усны нөөц, горим, газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх магадлалтай тул төслийн сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

1. Үйлдвэрийн орчны ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх
2. Шатаах зуух болон үйлдвэрийн үндсэн барилга байгууламжийг стандартад нийцүүлэх
3. Үйл ажиллагаа явуулж буй хорооны удирдлагуудтай хамтран байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр үйл ажиллагааг хамтран зохион байгуулах

4.2 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийг хэрэгжүүлэх явцдаа үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаагийн хувьд БОНБНУ-ний тайланд тусгагдсан зөвлөмжийг баримтлан ажиллах. Тухайлбал үйл ажиллагааны явцад байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж түүний дагуу арилгах, бууруулах арга хэмжээнүүдийг авч ажиллах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах.

4.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Элемент Медикал” ХХК нь “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал цуглуулах, устгах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэхдээ, байгаль орчны экологийн горимыг аль болох алдагдуулахгүй байх, нөхөн сэргээх ажлыг зохих түвшинд чанартай гүйцэтгэж, төслийн сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээний талаар БОНБНУ-ний тайланд тусгагдсан зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, мөн төслийн үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллах зорилт тавьж ажиллаж байгаа болно.

4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжих талбайн орчим үүсч болох байгалийн, хүний үйл ажиллагааны гаралтай аюулт үзэгдлийн талаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дэлгэрэнгүй тусгасан бөгөөд эдгээр аюулт үзэгдэл үүсэх шалтгаан, давтамж, үр дагавраас урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга хэмжээний талаар мөн тайлангийн 6-7 дугаар бүлэгт тусгагдсан. Үнэлгээний явцад байгалийн, хүний үйл ажиллагааны гаралтай аюулт үзэгдэл болон тус төслийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийн түвшинг үнэлсэн бөгөөд эрсдэлийн үнэлгээнээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас хамгийн их эрсдэл үүсгэх хүчин зүйл бол хөдөлмөр хамгаалах, техникийн аюулгүй байдал алдагдахтай холбоотой болох нь харагдаж байна. Үүнтэй холбогдуулан осол, эрсдэлийн менежментийн чиглэлээр хийх арга хэмжээг 5-р бүлэгт дэлгэрэнгүй дурдсан болно.

4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн БОНБНУ-ний тайлан дээр тусгагдсан 8 чиглэлийн 35 бүлэг үйл ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хууль эрхзүйн бүлэгт орсон хууль, дүрэм журам, стандарт болон Олон улсын конвенцийн холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Ингэснээр төслөөс бий болох болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. ОХШХ-ийг жил бүр шинэчлэн боловсруулж, хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлэх тухайн оны эхэнд БОНХАЖЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн БОНХАЖЯ болон УМХГ-т тайлагнана. Төслийн байгаль орчны нөлөөллийг тогтоохын тулд дараах хоёр бүсэд ОХШХ-ийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нөлөөллийн цөм бүс
2. Нөлөөлөлд өртөгч бүс

Нөлөөллийн цөм бүс нь тухайн төслийн хэрэгжилт, хамрах талбайн хил заагаар хязгаарлагдана. Энэ хэсэгт ОХШХ-т туссан байгалийн объект бүрээс дээж авах ба нөлөөлөлд өртөгч бүс нь хамрагдах газрын заагаас гадагш бүх зүгт жигд тархалттай байх тул тус төслийн хувьд хамгийн ихдээ 1.0 км байхаар тооцлоо. Энэ бүсэд ОХШХ-т туссан байгалийн объект бүрээс дээж авах шаардлагагүй ба тухайн төслийн онцлог, байгаль цаг уурын нөхцөлөөс хамаарч 1 болон түүнээс олон тооны хяналтын цэг тогтоогдох боломжтой. Хяналтын цэгүүдийг сонгохдоо тухайн байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн онцлог, шилжилт хөдөлгөөн, төслийн нөлөөлөл, эрчим зэрэг хүчин зүйлийг харгалзана. ОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ хяналтын цэгүүдэд заагдсан хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийлгэх ба хяналтын цэгүүдийн байршлыг өөрчлөх боломжтой.

4.6.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Шинжилгээний байршил: Төслийн талбайд

Хяналтын хугацаа, давтамж: Улиралд 1 удаа

Хэрэглэгдэх тоног төхөөрөмж: Улсын эсвэл мэргэжлийн байгууллагын итгэмжлэгдсэн лаборатори

Баримтлах стандарт, аргачлал:

-MNS 5885:2008-Агаар бохирдуулах органик биш бодисын хүлцэх хэм хэмжээ

-MNS 4585:2007-Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж

4.6.2 Хөрсөн орчны хяналт шинжилгээ

Шинжилгээний байршил: Төслийн талбайд

Хяналтын хугацаа, давтамж: Намар 9-р сарын 15±5 хоног

Хэрэглэгдэх тоног төхөөрөмж: Улсын эсвэл мэргэжлийн байгууллагын итгэмжлэгдсэн лаборатори

Баримтлах стандарт, аргачлал:

-MNS 2305-1994-Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах, журам

-MNS 3298-1990 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага

MNS 5850-2008 - Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

4.6.3 Усан орчны хяналт шинжилгээ

Шинжилгээний байршил: Төслийн талбайд

Хяналтын хугацаа, давтамж: Намар 9-р сарын 15±5 хоног

Хэрэглэгдэх тоног төхөөрөмж: Улсын эсвэл мэргэжлийн байгууллагын итгэмжлэгдсэн лаборатори

Баримтлах стандарт, аргачлал:

-MNS ISO 5667-1-2002 Усны чанар. Дээж авах, 1-р хэсэг. Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар

-MNS ISO 5667-6-2001 Усны чанар. Дээж авах, 6-р хэсэг. Гол горхины уснаас дээж авах заавар

4.7 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Оролцогч талууд: ы

- НБОГ
- Орон нутгийн захиргаа ба ИТХ
- Нөлөөллийн бүс дэх оршин суугчид ба ажилчид

Тайлагнах шаардлага:

Тус төслийн хүрээнд оролцогч талуудад бодит мэдээллийг хүргэх, БОАЖС-ын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг хэрэгжүүлэх, оролцогч талуудын саналыг байгаль хамгаалах үйл ажиллагаандаа тусгах

№	Оролцогч талууд	Хэлбэр	Агуулга	Хугацаа	Санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	НБОГ	Тайлан	БОМТ	10 сарын 25 12 сарын 25	БОМТ	НБОГ
2	Орон нутгийн захиргаа болон ИТХ	Тайлан Уулзалт				Захиргааны байр
4	Нөлөөллийн бүс дэх оршин суугчдад	Тайлан Уулзалт				Төсөл хэрэгжүүлэгчийн байр

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь хөрс, газрын гадарга, ургамал, амьтан байна.	Үйлдвэрийн талбайн хойд хэсгээр мод тарих ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Төслийн нийт талбайн хэмжээнд	м ²	1.000.0 төгрөг	500м ² талбайд гацуур, улиас, бургас г.м мод тарих	2.000.0 төгрөг	2, 3-р улиралд	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль -Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль -Газрын тухай хууль - Газрын хэвлийн тухай хууль -Хөрс хамгаалах цөлжилтөөс
2		Хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэлийг багасгах, агаар дахь тоосонцорын хэмжээг бууруулах зорилгоор ногоон байгууламж (олон наст зүлэг тарих) байгуулсан байна	Төслийн нийт талбайн хэмжээнд	м ²	500.0 төгрөг	Хатуу хучилттай хэсгээс бусад 200м ² талбайг ногоон байгууламжтай болгох	1.000.0 төгрөг		

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

3	Төслийн аль ч үе шатанд цэвэрлээгүй бохир усыг байгаль орчинд хаяхгүй байх арга хэмжээг зохион байгуулж ажиллах (технологийн хэрэглээний усыг багасгах оновчтой аргыг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлийг бий болгох)	Төслийн үйл ажиллагааны нутаг дэвсгэрт	тн	500.0 төгрөг	Үйлдвэрийн орчин	1.000.0 төгрөг	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	урьдчилан сэргийлэх тухай -Агаарын тухай хууль -Усны тухай хууль - Хог хаягдлын тухай хууль -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль -MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
4	Технологийн хэрэгцээнд ашигласан усны химийн найрлагын бүртгэл хяналт шинжилгээг тогтмол хийх	Төслийн үйл ажиллагааны нутаг дэвсгэрт	Иж бүрэн	1.500.0 -	Үйлдвэрийн орчин	2.500.0	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	- MNS 6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
5	Хөдөлгүүрт техник тоног төхөөрөмжид тогтсон хуваарийн дагуу засвар үйлчилгээг хийх замаар яндангийн утааг багасгах	Нийт техник, тоног төхөөрөмж	-	Дотоод зардал	Үйлдвэрийн орчин	-	Тогтмол	-MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
6	Аюултай хог хаягдлыг шатаах зуухны хөөг цэвэрлэх орчин үеийн технологийг	Шатаах зуух	Иж бүрэн	Дотоод зардал	Үйлдвэрийн орчин	-	Тухайн жилдээ	

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

	судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх								-MNS 5918:2008 БО. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага -
7	Үйлдвэрийн агаар бохирдуулах эх үүсвэр болох шатаах зууны байрны ойролцоох хэсэг газрын сул шороотой хэсгийг хэлбэршүүлэн засч, хөрсний шимт чанарыг нь сайжруулан ургамалжуулах (агаарын бохирлыг бууруулах хоргүйжүүлэх ургамлын төрөл зүйлийн судалгаанд үндэслэх)	Шатаах зуухны ойролцоох хэсэг газар	Багц	Дотоод зардал	50м ² талбайд	Дотоод зардал	Тухайн жилдээ		

2. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Үйлдвэрийн орчин болон ландфиллын талбайн орчны нийт 3 цэгээс агаарын чанар, дуу шуугианы хяналт	Үйлдвэрийн орчин Хог хаягдлын	Улирал тутам	Жилд 4 удаа	200.0 төгрөг	400.0 төгрөг	Шинжилгээний дүгнэлт, хариу гарсан байх	-MNS 5885:2008- Агаар бохирдуулах органик биш бодисын хүлцэх хэм хэмжээ

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

	шинжилгээ хийлгэх	ландфиллын талбай						-MNS 4585:2007-Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж
2	Үйлдвэрийн орчин болон ландфиллын талбайн орчны нийт 2 цэгээс хөрсний шинжилгээ хийлгэх	Үйлдвэрийн орчин Хог хаягдлын ландфиллын талбай	Улирал тутам	Жилд 4 удаа	200.0 төгрөг	400.0 төгрөг	Шинжилгээний дүгнэлт, хариу гарсан байх	-MNS 2305-1994-Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах, журам - MNS 5850-2008 - Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	Үйлдвэрийн гүний худгаас усны шинжилгээ хийлгэх	Үйлдвэрийн орчин	Улирал тутам	Жилд 4 удаа	200.0 төгрөг	400.0 төгрөг	Шинжилгээний дүгнэлт, хариу гарсан байх	-MNS 4586-1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. - MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
4	Үйлдвэрийн бохир усны цооногоос хаягдал усны шинжилгээ хийлгэх	Үйлдвэрийн орчин	Улирал тутам	Жилд 4 удаа	250.0 төгрөг	1.000.0 төгрөг	Шинжилгээний дүгнэлт, хариу гарсан байх	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
5	Шатаах зуухны яндангаар гарах утаанд агаарын шинжилгээ хийлгэх	Үйлдвэрийн орчин	4-р улиралд – 1 удаа	Жилд 1 удаа	350.0 төгрөг	700.0 төгрөг	Шинжилгээний дүгнэлт, хариу гарсан байх	

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

6	Үйлдвэрийн орчинд орчны болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтийг тогтсон цэгүүдээр хийлгэж дүгнүүлэх	Үйлдвэрийн орчин	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	Жилд 1 удаа	2.000.0 төгрөг	2.000.0 төгрөг	Хэмжилтийн дүн гарсан байна	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, -MNS4968:2000. ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага -MNS 4996 : 2000. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага -MNS 5002 : 2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS 6342 :2012 Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
7	Дээрх шинжилгээний дүгнэлт болон хэмжилтийн дүнг үндэслэн урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах хамгийн оновчтой арга, туршлагауудыг хэрэгжүүлэх	Үйлдвэрийн орчин	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	Тухайн жилд	Дотоод зардлаар	-	Авсан арга хэмжээний тайлан гарсан байна	
8	Үйлдвэр орчмын үерийн хамгаалалт, даланд тогтмол үзлэг хийж хянаж байх	Үйлдвэрийн орчин	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	Тухайн жилд	Дотоод зардлаар	-	Үзлэг, хяналт хийж хөтөлсөн баримт бичиг	
9	Ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн эрхтэй болох	Үйлдвэрийн орчин	2, 3-р улиралд	Тухайн жилд	-	-	Үйлдвэрийн байр, тээврийн хэрэгслүүдэд тогтмол халдваргүйтгэлийг хийж хэвшсэн байна	

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө									
№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Байгаль орчны экологийн горимыг аль болох алдагдуулахгүй байх, нөхөн сэргээх ажлыг зохих түвшинд чанартай гүйцэтгэж, төслийн сөрөг нөлөөллийг багасгах, арилгах	Тухайн онд ашигласан ландфиллын талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, эвдэрсэн газрыг засах	Хог хаягдлын ландфиллын талбай	Га	1 га талбай	10.000.0 төгрөг	10.000.0 Төгрөг	Аюултай хог хаягдлын ландфиллын талбайн техникийн нөхөн сэргээлт хийгдсэн, тус ажлыг гүйцэтгэсэн тухай ажлын тайлан гарсан байна	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Хог хаягдлын тухай хууль -ЭМС-ын А/505 дугаар тушаал -MNS 5914:2008 БО. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт -MNS 5918:2008 БО. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
2		Аюултай хог хаягдлын ландфиллийн талбайг журам, стандартад нийцүүлэн сайжуулах	Хог хаягдлын ландфиллын талбай	Га	1 га талбай	15.000.0 төгрөг	15.000.0 Төгрөг	Ландфиллийн талбайн зураг төсөл гарсан, зураг төслийн дагуух алууд хийгдсэн байна.	

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө							
№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар (1-4)	Сар (5-8)	Сар (9-12)		
1	2	3	4	5	6	7	
1	БО-ы удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоох, БО-г хамгаалах асуудлаар байгууллагын ажилтан, ажилчин бүрийн хариуцах ажил, хүлээх үүргийг тогтоон өгч ажил үүргийн хуваарь, хөдөлмөрийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх	-	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд тогтмол хэрэгжүүлэх			Элемент Медикал ХХК	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, -Хөдөлмөрийн тухай хууль -MNS ISO 14001:2016 - Хүрээлэн байгаа орчны удирдлага-Байгаль орчны менежментийн тогтолцоо MNS 4219:1994 -Байгаль орчныг хамгааллын стандартын систем. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм
2	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр өөрийн ажилтан, ажилчдын дунд сургалт семинарыг улиралд нэг удаа тогтмол зохион байгуулах	Дотоод зардлаар	Тогтмол			Элемент Медикал ХХК	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль
3	Байгаль орчныг хамгаалах ажлын жилийн тайлан, төлөвлөгөөгөөг БОАЖЯ, НБОГ болон орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх	Дотоод зардлаар	-	-	Хийсэн ажлын үр дүн, тайлан	Элемент Медикал ХХК	-БОАЖС-ын А-618 дугаар тушаал

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

4	Газар, ус ашигласны төлбөрийг орон нутгийн төсвийн дансанд тухай бүрт хугацаа алдалгүй төлж байх					- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай - Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай - Ус бохирдуулсны төлбөрийн тухай -Газрын төлбөрийн тухай
5	Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй бусад зардал	Дотоод зардлаар	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд тогтмол хэрэгжүүлэх		Элемент Медикал ХХК	
6	Ажилчдыг ажилд гарахын өмнө архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхэд хяналт тавьж ажиллах, ажлын байранд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хатуу хориглох	-	Жилийн турш тогтмол		Элемент Медикал ХХК	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,
7	Ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэл, амны хаалт, чихэвч, чихний бөглөө, бээлий, гутал, нүдний шил зэргээр хангах	±30.000.0	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд		Элемент Медикал ХХК	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,
8	Тээврийн хэрэгслийн дулаан гражийн хүрэлцээг нэмэгдүүлэх	Дотоод зардлаар	2, 3-р улиралд	-	Элемент Медикал ХХК	-
9	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Дотоод зардлаар	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд		Элемент Медикал ХХК	-

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

10	Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдэд учирсан гэмтлийг тухай бүр янзалж, дотоод шаталтын хөдөлгүүрийг засварлаж, шинэчлэх	Дотоод зардлаар	Тогтмол	Элемент Медикал ХХК	-
11	Үйлдвэрийн ажилчдыг мэргэжлийн дагуу мэргэшсэн сургалтад хамруулан, мэдлэг, ур чадварыг үе шаттай дээшүүлэх	Дотоод зардлаар	Тогтмол	Элемент Медикал ХХК	-Хөдөлмөрийн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль

5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө								
№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн болон үйлдвэрийн тоног	Эрсдлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Үйлдвэрийн орчин	-	-	Дотоод зардал	1-р улиралд	-Гамшгаас хамгаалах тухай хууль, -Галын аюулгүй байдлын тухай хууль,
2	төхөөрөмж, тээврийн хэрэгслийн гэнэтийн осол эрсдэл	Гал түймэр эсэргүүцэх ажлын зохион байгуулалт, багаж хэрэгслийн бүрдлийг шинээр бий болгох	Үйлдвэрийн орчин	Иж бүрэн	1.000.0	2.000.0	Тухайн жилд	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

3	Ажлын байрны тоног төхөөрөмжийн болон бусад гэнэтийн осол гэмтэл, ажилтны болгоомжгүй үйлдлээс үүсэж болзошгүй сөрөг үр давар	Нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр (ажлын хувцас, өвөл, зуны гутал, хамгаалалтай нүдний шил, бээлий, чих бөглөгч г.м) хангах	Үйлдвэрийн орчин	Иж бүрэн	3.000.0	6.000.0	Тухайн жилд	-Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, - Эрүүл ахуйн тухай хууль -Эрүүл мэндийн тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичиг
4		Ажилчдад ослын үед цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх зорилготой анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулсан байна.	Үйлдвэрийн орчин	Иж бүрэн	250.000	500.000	Тухайн жилд	
5	Ажилчдын мэдлэг чадвар дутмагаас үүдэх сөрөг үр дагавар	Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтанд тогтмол хамруулж байх, биелэлтэд хяналт тавих	Үйлдвэрийн орчин	Багц цагийн	500.000	1.000.0	Тогтмол	
6	Ажлын байрны болзошгүй аюул, осол гэмтэл	Ажлын байрны аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, плакат, тэмдэг өлгөх зэрэг зайлшгүй арга хэмжээнүүдийг авч хяналт тавьж байх	Үйлдвэрийн орчин	-	250.000	500.000	Тогтмол	

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

7		ХХАА - ны дүрэм заавар дотоод журмыг боловсруулах, танилцуулах, сургалт зохион байгуулах	Үйлдвэрийн орчин	-	-	-	Тогтмол	
8	Цахилгаан тоног төхөөрөмжийн гэнэтийн осол эрсдэл	Цахилгааны холболт, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах, жил бүр хяналт үзлэг зохион байгуулах	Үйдвэрийн орчин	Иж бүрэн	-	-	Тогтмол	
9	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа алдагдах	Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар болон гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар мэдлэг олгох сургалтанд тогтмол хамруулж байх, биелэлтэд хяналт тавих	Үйдвэрийн орчин	Нийт ажилчид	-	Дотоод зардал	Тогтмол	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, -Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, -Галын аюулгүй байдлын тухай хууль,
10	Нэг ажлын байранд удаан хугацаагаар ажилласан ажилчны мэргэжлээс шалтгаалах өвчинд өртөх эрсдэл	Ажилчдыг УСҮ-т жилд 1 удаа тогтмол хамруулах байгуулах	Үйдвэрийн орчин	Нийт ажилчид	200.0	4.000.0	Жилд 1 удаа /1-р улиралд/	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, -Эрүүл мэндийн тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичиг

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

11	Авах арга хэмжээ удаашрах цаашлаад эрүүл мэнд, амь насан эрсдэл учрах сөрөг үр дагавартай	Ажилчдыг ослын үед өөртөө болон бусдад үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламжийн арга барилд сургах арга хэмжээ	Үйдвэрийн орчин	Нийт ажилчид	-	Дотоод зардал	Тогтмол	
12	Галын аюулгүй байдал алдагдах эрсдэл	Галын хорны ажиллагааг тогтмол шалгаж тэмдэглэл хөтлөх	Үйдвэрийн орчин	Иж бүрэн	-	Дотоод зардал	Тогтмол	-Галын аюулгүй байдлын тухай хууль,
13	Байгалийн болон үйлдвэрийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн гэнэтийн осол эрсдэл	Тээврийн хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх засвар үйлчилгээ хийх талбайг тусгайлан засч тохижуулах	Үйдвэрийн орчин	Иж бүрэн	-	Дотоод зардал	Тухайн жилдээ	-Галын аюулгүй байдлын тухай хууль,

6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Аюултай	БОННУ-д тусгасны дагуу 8 чиглэлийн 35 бүлэг үйл ажиллагааны зөвлөмжийг	Үйлдвэрийн орчин, Хог хаягдлын	-			Дотоод зардлаар	Төслийн үйл ажиллагаа	-Хог хаягдлын тухай хууль, -ЭМС-ын А/505 дугаар тушаал,

“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он

	хэрэгжүүлэн ажиллах	ландфиллын талбай, Бүх харилцагч ЭМБ-ууд					явуулах хугацаанд	-БОАЖС-ын А/21 дугаар тушаал - Олон улсын зөвлөмж
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг батлуулан, түүний хэрэгжилтийг ханган ажиллах	Үйлдвэрийн орчин,	-	Дотоод зардлаар			Тухайн жилд	-Хог хаягдлын тухай хууль, ЗГ-ын 2018 оны 116-р тогтоолын
3	Хог хаягдлын цэгийг тогтмол халдваргүйжүүлж байх	Үйлдвэрийн орчин, Хог хаягдлын ландфиллын талбай	иж бүрэн	-	-	-	Тогтмол	-МУ-ын хог хаягдлын тухай хууль - Олон улсын зөвлөмж - Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
4	Аюултай хог хаягдлын менежментийн чиглэлээр шинэ болон байнгын ажилчдад тогтмол сургалт зохион байгуулан мэдлэгийг дээшлүүлж байх	Нийт ажилчид	Багц цагийн	-	-	-	Тогтмол	-Хог хаягдлын тухай хууль, -ЭМС-ын А/505 дугаар тушаал, -Хог хаягдлын тухай хууль, ЗГ-ын 2018 оны 116-р тогтоол
5	Бутлах машины хүчин чадал нэмэгдүүлэх	Үйлдвэрийн орчин	иж бүрэн	±50.000.0	1	±100.000.0	Төслийн үйл ажиллагаа явуулах хугацаанд	-Хог хаягдлын тухай хууль, -ЭМС-ын А/505 дугаар тушаал,

**“Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг устгах үйлдвэр”-ийн
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2025 он**

6		ТҮК-тэй ахуйн хог хаягдал устгах гэрээ байгуулж жил бүр шинэчилж байх	Үйлдвэрийн орчин	-	Дотоод зардал	1-р улиралд	-Хог хаягдлын тухай хууль,
7		Хог хаягдлын тухай хууль болон Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, бүртгэх, тайлагнах журмын шаардлагыг хэрэгжүүлэх	Төслийг хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаанд мөрдөж ажиллах	Иж бүрэн	Дотоод зардлаар	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	-Хог хаягдлын тухай хууль, -ЗГ-ын 2018 оны 116-р тогтоолын 1 дүгээр хавсралт, -БОАЖС-ын 2018 оны А/18 дугаар тушаал

7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	СХД-ийн 36-р хорооны Засаг дарга, ИНХ-ын дарга, Нөлөөллийн бүсийн оршин суугчид	БОМТ-ний хэрэгжилтийн талаар тайлагнах	Төслийн үйл ажиллагаа түүний үр дагавар, БОНБНҮ, БОМТ-нд тусгасан ажлууд болон түүний хэрэгжилтийн тухай	жилд 1 удаа	300.0	Элемент Медикал ХХК	СХД-ийн 36-р хорооны ИНХ-ын танхим